



МОНГОЛ УЛСЫН
ХОТ БАЙГУУЛАЛТ, БАРИЛГА,
ОРОН СУУЦЖУУЛАЛТЫН САЙДЫН
ТУШААЛ

2025 оны 02 сарын 10 өдөр

Дугаар 36

Улаанбаатар хот

Барилгын үйл ажиллагааны
тусгай зөвшөөрлийн нөхцөл,
шаардлага батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын Яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.13 дахь заалт, Барилгын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.15 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилгын ажил гүйцэтгэх, барилгын материалын үйлдвэрлэл, өргөх байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл, угсралт, засвар үйлчилгээ эрхлэх хуулийн этгээдэд үйлчилгээний хөлс тогтоох, хяналт тавих нөхцөл, шаардлага”-ыг хавсралтаар баталсугай.

2. Энэ тушаалыг холбогдох байгууллагуудад хүргүүлэх, нийтэд мэдээлэх, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулахыг Барилга, барилгын материалын бодлого зохицуулалтын газарт үүрэг болгосугай.

3. Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /С.Төмөрхүү/-д даалгасугай.



Ж.БАТСУУРЬ

1525010104

Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын
сайдын 2025 оны 11 дугаар сарын 10-ний
өдрийн 11 дугаар тушаалын хавсралт

**БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЗУРАГ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ,
БАРИЛГЫН АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ, БАРИЛГЫН МАТЕРИАЛЫН ҮЙЛДВЭРЛЭЛ,
ӨРГӨХ БАЙГУУЛАМЖ, ТҮҮНИЙ ЭД АНГИЙН ҮЙЛДВЭРЛЭЛ, УГСРАЛТ, ЗАСВАР
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН НӨХЦӨЛ, ШААРДЛАГА**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү нөхцөл шаардлагын зорилго нь барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилгын угсралтын ажил гүйцэтгэх, барилгын материалын үйлдвэрлэл, өргөх байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл, угсралт, засвар үйлчилгээг эрхлэх /Цаашид "барилгын үйл ажиллагаа" гэх/ тусгай зөвшөөрөл /Цаашид "Зөвшөөрөл" гэх/-ийн нөхцөл, шаардлага, үйлчилгээний хөлсийг тогтоох, тэдгээр нэмэлт, өөрчлөлт оруулах, тусгай зөвшөөрлийн гэрээ, гэрчилгээний загварыг батлахад оршино.

1.2. Барилгын үйл ажиллагааны зөвшөөрлийн нөхцөл, шаардлага нь барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилгын угсралтын ажил гүйцэтгэх, барилгын материалын үйлдвэрлэл, өргөх байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл, угсралт, засвар үйлчилгээг эрхлэх хуулийн этгээдийн үйл ажиллагааг барилга, байгууламжийн норм нормативын баримт заасан шаардлагад нийцүүлэхэд чиглэнэ.

Хоёр. Ерөнхий нөхцөл, шаардлага

2.1. Зөвлөх, тэргүүлэх зэрэгтэй инженер нь 4 хүртэл аж ахуй нэгж, байгууллагад, мэргэшсэн зэрэгтэй инженерийн 2 хүртэл аж ахуй нэгж, байгууллагад бүртгүүлэх.

2.2. Монгол Улсын зөвлөх, мэргэшсэн зэрэгтэй инженерийн баримт бичгийг барилгын салбарын зөвлөх, мэргэшсэн зэрэгтэй дүйцүүлэх.

2.3. Хос мэргэжилтэй салбарын инженер, техникийн ажилтан нь тухайн мэргэжил тус бүрийг давхцуулалгүйгээр өөр өөр байгууллагууд бүртгэх.

2.4. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй хариуцсан ажилтан нь инженер, техникийн ажилтан болон эрүүл ахуйн боловсролтой, мэргэшсэн ажилтан байна.

2.5. Инженер, техникийн ажилтны мэдээлэлд барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн мэдээллийн санд баталгаажсанаас хойш 90 хоногийн дараа шилжилт хөдөлгөөн хийж болох ба шилжилт хөдөлгөөн хийсэн тохиолдолд орон гарсан инженер, техникийн ажилтныг 90 хоногийн дотор нөхөх.

2.6. Зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээд нь энэ нөхцөл шаардлагыг 3 дугаар хавсралтаар баталсан үйлчилгээний хөлсийг төлсөн байх.

2.7. Барилгын үйл ажиллагааны зөвшөөрлийн гэрээ нь тоон гарын үсэг, QR код (түргэн хариултын код)-той, тусгай зөвшөөрлийн гэрчилгээ нь QR кодтой байна.

Ж

2.8. Барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл сунгуулах, нэмэлт ажлын төрөл авах бол тусгай зөвшөөрөл эзэмшиж байх хугацаанд хийж гүйцэтгэсэн ажлын гэрээ, Барилгын салбарын норм нормативын санд төлбөр төвлөрүүлсэн баримтыг ирүүлсэн байх.

2.9. Компаниудын нэгдэл буюу групп компани нь мега төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхийн тулд барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл авах шаардлага үүссэн тохиолдолд өөрийн охин буюу салбар аж ахуйн нэгж, байгууллагын инженер, техникийн ажилчдын мэдээллийг ашиглан тусгай зөвшөөрлийн шаардлагыг хангуулж болно.

Гурав. Үйл ажиллагааны чиглэл тус бүрт тавигдах тусгай нөхцөл, шаардлага

3.1. БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЗУРАГ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХҮРЭЭНД:

3.1.1.Бага төвөгшилтэй барилга байгууламжийн зураг төсөл.

Ажлын төрөл	Нөхцөл	Шаардлага
ЗТ-2.1 Барилга байгууламжийн архитектур орчны тохижилтын зураг төсөл ¹	-Архитектор-1	Архитектор нь 3-с доошгүй жил ажилласан байх
ЗТ-2.1* Барилга бүтээцийн зураг төсөл	-Барилгын инженер-1	Барилга байгууламжийн бүтээцийн зураг төслийн инженер нь 3-с доошгүй жил ажилласан байх
ЗТ-2.2 Усны барилга байгууламжийн зураг төсөл ²	-Усны барилга байгууламжийн инженер болон усны нөөц, усжуулалтын инженер-2	ИТА-ын аль нэг нь усны барилга байгууламжийн зураг төслийн чиглэлээр 3-с доошгүй жилийн туршлагатай байх

3.1.2. Дунд болон өндөр төвөгшилтэй барилга байгууламжийн зураг төсөл

(*ЗТ-3.1-ЗТ-3.7-д хамрагдах заалт нь ЗТ-4.1-ЗТ-4.7-р заалттай адил буюу өндөр төвөгшилтэй барилга байгууламжид хамаарна.)

Ажлын төрөл	Нөхцөл	Шаардлага
ЗТ-4.1 Барилга байгууламжийн архитектур, барилга бүтээцийн зураг төсөл, орчны тохижилт ³	-Архитектор-2 -Барилгын инженер-2	Архитекторын аль нэг нь барилгын архитектур /эзлэхүүн/ төлөвлөлтийн мэргэшсэн эсхүл зөвлөх зэрэгтэй байх; Барилгын инженерийн аль нэг нь барилга байгууламжийн бүтээцийн зураг төслийн мэргэшсэн эсхүл зөвлөх зэрэгтэй байх.

¹ Барилга байгууламжийн төвөгшлийн ангиллын төрөлд хамаарагдах орон сууц, төрөл бүрийн зориулалттай олон нийтийн барилга, сургуулийн өмнөх боловсролын байгууллага, сургууль, дотуур байр, эмнэлгийн, худалдаа, үйлчилгээний, авто машины зогсоолын, цамхаг, тулгуур, түшиц хана түүнтэй адил байгууламж, хөдөө аж ахуйн зориулалттай, түр барилга байгууламжуудын зураг төсөл багтсан

² Барилга байгууламжийн төвөгшлийн ангилалд хамаарах 100 га хүртэл усалтын систем, 100 мян.га хүртэлх усан мандлын талбайтай хөө цөөрмийн барилга байгууламж, 1000м²/га хүртэлх барилгын нягттай хот суурины борооны ус зайлуулах систем, ХАА болон бэлчээр усжуулалтын уст цэгүүд, инженерийн хийцтэй усан оргилуурууд багтана.

³ Барилга байгууламжийн төвөгшлийн ангиллын төрөлд хамаарагдах орон сууц, төрөл бүрийн зориулалттай олон нийтийн барилга, сургуулийн өмнөх боловсролын байгууллага, сургууль, дотуур байр, эмнэлгийн, мэдээлэл, холбоо-сүлжээний барилга байгууламж, худалдаа, үйлчилгээний, авто машины зогсоолын цамхаг, тулгуур, түшиц хана түүнтэй адил барилга байгууламжуудын зураг төсөл багтсан

ЗТ-4.2 Усны барилга байгууламжийн зураг төсөл ⁴	-Усны барилга байгууламжийн инженер-2	Усны барилга байгууламжийн инженерийн аль нэг нь усны барилга байгууламжийн зураг төслийн мэргэшсэн эсхүл зөвлөх зэрэгтэй байх
ЗТ-4.3 заалтыг хассан		
ЗТ-4.4 Ус хангамж, ариутгах татуургын гол (магистраль) шугам сүлжээ, түүнтэй холбогдох барилга, байгууламжийн технологийн ажлын зураг	-Ус хангамж, ариутгах татуургын инженер-2	Ус хангамж, ариутгах татуургын инженерийн аль нэг нь ус хангамж, ариутгах татуургын системийн зураг төслийн мэргэшсэн эсхүл зөвлөх зэрэгтэй байх
ЗТ-4.5 Дулаан хангамжийн гол (магистраль) шугам сүлжээ, түүнтэй холбогдох барилга, байгууламжийн технологийн ажлын зураг	-Дулааны инженер-2	Дулааны инженерийн аль нэг нь дулаан хангамж, агаар сэлгэлтийн системийн зураг төслийн мэргэшсэн зэрэгтэй эсхүл зөвлөх зэрэгтэй байх
ЗТ-4.6 Газрын тос, газрын тосны бүтээгдэхүүн, хийн барилга байгууламжийн орчны ерөнхий төлөвлөгөө, тохижилт, өндөржилт, барилга бүтээц, технологийн ажлын зураг төсөл	-Газрын тос, газрын тосны бүтээгдэхүүн, хий хангамжийн барилга байгууламжийн зураг төслийн инженер-1 -Газрын тосны хадгалалт тээвэрлэлтийн инженер-1 -Архитектор-1 -Барилгын инженер-1	Газрын тос, газрын тосны бүтээгдэхүүн, хийн хангамжийн барилга байгууламжийн зураг төслийн инженерийн аль нэг нь газрын тос, газрын тосны бүтээгдэхүүн, хийн хангамжийн барилга байгууламжийн зураг төслийн мэргэшсэн эсхүл зөвлөх зэрэгтэй байх Барилгын инженер нь 5-с доошгүй жил ажилласан туршлагатай байх
ЗТ-4.7 Уул-уурхайн технологийн зураг төсөл, ТЭЗҮ	-Уул уурхайн менежмент-1 -Уул уурхайн ашиглалтын технологи инженер-2	Уул уурхайн ашиглалтын технологи инженерийн нэг нь мэргэшсэн эсхүл зөвлөх зэрэгтэй байх
ЗТ-4.8 Түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийн сэргээн засварлалтын зураг төсөл	-Архитектор-2 -Барилгын инженер-1	Архитекторын аль нэг нь зөвлөх зэрэгтэй байх Барилгын инженер нь барилга байгууламжийн бүтээцийн зураг төслийн мэргэшсэн зэрэгтэй байх
ЗТ-4.9 заалтыг хассан		
ЗТ-4.10 Мэдээлэл, холбоо-дохиоллын дамжуулах (магистраль) болон салбар шугам сүлжээ түүнтэй холбогдох барилга байгууламжийн ажлын зураг	-Мэдээлэл, харилцаа холбооны инженер-3	Мэдээлэл, холбооны инженерийн аль нэг нь барилга байгууламжийн мэдээлэл, холбоо дохиоллын системийн зураг төслийн мэргэшсэн эсхүл зөвлөх зэрэгтэй байх

3.1.3. Онцгой төвөгшилтэй барилга байгууламжийн зураг төсөл.

Ажлын төрөл	Нөхцөл	Шаардлага
ЗТ-5.1 Онцгой төвөгшилтэй барилга байгууламжийн архитектур, барилга бүтээц, инженерийн	- Архитектор-2 - Барилгын инженер-2 - УХАТ-ын инженер-1 - ХАС-ийн инженер-1	Архитекторын нэг нь барилгын архитектур /эзлэхүүн/ төлөвлөлтийн мэргэшсэн зэрэгтэй эсхүл архитектур /эзлэхүүн/

⁴ Барилга байгууламжийн төвөгшлийн ангилалд хамаарах БНБД33-01-03-р тодорхойлогдох II ангийн усны үндсэн барилга байгууламжууд II-IV ангийн усан цахилгаан станцын барилга, дулаан цахилгаан станцын усны барилга байгууламжууд, /хөрөөлтийн систем, үнсэн сан, эргэлтийн усны систем/, 101м³/х дээш багтаамжтай ус татамжийн барилга байгууламжууд багтана.

22

хангамж, технологийн зураг төсөл орчны тохижилт ⁵	- Цахилгаан инженер-1 - Мэдээлэл холбоо, дохиоллын инженер-1 - Автоматжуулалтын инженер-1	төлөвлөлтийн зөвлөх зэрэгтэй байх; Барилгын инженерийн алв нэг нь барилга байгууламжийн бүтээцийн зураг төслийн мэргэшсэн эсхүл зөвлөх зэрэгтэй байх; Инженер хангамжийн инженерүүд нь тухайн чиглэлээр 3-с доошгүй жил ажилласан байх <i>Зөвлөх үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдтэй гэрээ байгуулсан байна.</i>
ЗТ-5.2 Усны барилга байгууламжийн зураг төсөл ⁶	- Усны барилга байгууламжийн инженер-2 - Тухайн чиглэлийн инженер-2 - УХАТ-ын инженер-1	Усны барилга байгууламжийн инженерийн аль нэг нь усны барилга байгууламжийн зураг төслийн мэргэшсэн зэрэгтэй байх, нөгөө нь усны барилга байгууламжийн зураг төслийн зөвлөх зэрэгтэй байх, Тухайн чиглэлийн инженерийн аль нэг нь мэргэшсэн эсхүл зөвлөх зэрэгтэй байх
ЗТ-5.3 Газрын тос, газрын тосны бүтээгдэхүүн, хийн барилга байгууламжийн орчны ерөнхий төлөвлөгөө, тохижилт, өндөржилт, барилга бүтээц, технологийн ажлын зураг төсөл	- Газрын тос, газрын тосны бүтээгдэхүүн, хий хангамжийн барилга байгууламжийн зураг төслийн инженер-1 - Газрын тос, газрын тосны бүтээгдэхүүн, хий хангамжийн барилга байгууламжийн механик инженер-1 - Газрын тосны хадгалалт тээвэрлэлтийн инженер-1 - Архитектор-1 - Барилгын инженер-2	Газрын тосны барилга байгууламжийн зураг төслийн инженер нь газрын тос, газрын тосны бүтээгдэхүүн, хийн хангамжийн барилга байгууламжийн зураг төслийн мэргэшсэн зэрэгтэй байх, Газрын тос, газрын тосны бүтээгдэхүүн, хийн хангамжийн барилга байгууламжийн зураг төслийн зөвлөх зэрэгтэй механик инженер байх, Барилгын инженерийн нэг нь мэргэшсэн зэрэгтэй байх
ЗТ-5.4 Газрын гүн дэх тусгай зориулалтын болон бусад барилга байгууламжийн зураг төсөл	- Архитектор-2 - Барилгын инженер-2 - Тухайн чиглэлийн технологийн инженер-2	Архитекторын нэг нь барилгын архитектур /эзлэхүүн/ төлөвлөлтийн мэргэшсэн зэрэгтэй байх, нөгөө нь барилгын архитектур /эзлэхүүн/ төлөвлөлтийн зөвлөх зэрэгтэй байх Барилгын инженерийн аль нэг нь барилга байгууламжийн бүтээцийн зураг төслийн мэргэшсэн зэрэгтэй

⁵ Барилга байгууламжийн төвөгшлийн ангиллын төрөлд хамаарагдах орон сууц, төрөл бүрийн зориулалттай олон нийтийн барилга, сургуулийн өмнөх боловсролын байгууллага, авто машины зогсоолын, цамхаг, тулгуур, түшиц хана түүнтэй адил барилга байгууламжуудын зураг төсөл багтсан.

⁶ Барилга байгууламжийн төвөгшлийн ангилалд хамаарагдах БНБД33-01-03-р тодорхойлогдох I ангийн усны үндсэн барилга байгууламжууд, I ангийн усан цахилгаан станцын барилга, атомын цахилгаан станцын усны барилга байгууламжууд (хөргөлтийн систем, үнсэн сан, эргэлтийн усны систем) багтана.

✓

		байх, нөгөө нь барилга байгууламжийн бүтээцийн зураг төслийн зөвлөх зэрэгтэй байх
3Т-5.5 Уул-уурхайн технологийн зураг төсөл, ТЭЗҮ	-Эдийн засагч /Уул уурхайн менежмент/-1 -Уул уурхайн ашиглалтын технологи инженер-3	Уул уурхайн ашиглалтын технологи инженерийн нэг нь мэргэшсэн нөгөө нь зөвлөх инженер байх

3.1.4.бага, Өндөр төвөгшилтэй барилга байгууламжийн дотор, гадна инженерийн салбар шугам сүлжээ, түүнтэй холбогдох барилга байгууламжийн зураг төсөл

Ажлын төрөл	Нөхцөл	Шаардлага
3Т-6.1 Барилга байгууламжийн дотор ус хангамж, ариутгах татуургын систем, гадна салбар шугам сүлжээ, түүнтэй холбогдох барилга байгууламжийн технологийн зураг төсөл	-Ус хангамж, ариутгах татуургын инженер-1	Ус хангамж, ариутгах татуургын инженер нь 3-с доошгүй ажилласан жилийн туршлагатай байх
3Т-6.2 Барилга байгууламжийн дотор халаалт, салхивч, хөргөлтийн систем, гадна дулааны салбар шугам сүлжээ, түүнтэй холбогдох барилга байгууламжийн технологийн зураг төсөл	-Халаалт агаар сэлгэлтийн инженер-1	Халаалт агаар сэлгэлтийн инженер нь 3-с доошгүй ажилласан жилийн туршлагатай байх
3Т-6.3 Барилга байгууламжийн дотор гэрэлтүүлэг, цахилгаан хангамжийн систем, 35кВ хүртэлх гадна салбар шугам сүлжээ, түүнтэй холбогдох барилга байгууламжийн технологийн зураг төсөл Орон сууц, олон нийт, үйлдвэрийн барилгын болон тоног төхөөрөмжийн хянах, хэмжих хэрэгсэл автоматикийн зураг төсөл	-Цахилгааны инженер-2	Цахилгааны аль нэг инженер нь 5-с доошгүй жил ажилласан туршлагатай байх
3Т-6.4 Барилга байгууламжийн дотор мэдээлэл холбоо, галын болон бусад дохиоллын системийн зураг төсөл, түүнтэй холбогдох барилга байгууламжийн технологи, гадна салбар шугам сүлжээний зураг төсөл	-Мэдээлэл, холбоо дохиоллын инженер-1	Мэдээлэл, холбоо дохиоллын инженер нь 3-с доошгүй ажилласан жилийн туршлагатай байх

3.1.5.гадна инженерийн шугам сүлжээ, түүнтэй холбогдох барилга байгууламжийн технологийн зураг

Ажлын төрөл	Нөхцөл	Шаардлага
3Т-7.1 Ус хангамж, ариутгах татуургын гол (магистраль) шугам сүлжээ, түүнтэй холбогдох барилга байгууламжийн технологийн зураг төсөл	-Ус хангамж, ариутгах татуургын инженер-2	Ус хангамж, ариутгах татуургын инженерийн аль нэг нь ус хангамж, ариутгах татуургын системийн зураг төслийн мэргэшсэн эсхүл зөвлөх зэрэгтэй байх
3Т-7.2 Дулааны бие даасан 5.0 МВт хүртэлх эх үүсвэрийн барилга	-Дулааны инженер-2	Дулааны инженерийн нэг нь дулаан хангамжийн зураг төслийн

Handwritten signature

байгууламжийн технологи, шугам сүлжээний зураг төсөл		мэргэшсэн, эсхүл зөвлөх зэрэгтэй байх Нөгөө инженер нь 3-с доошгүй жил ажилласан туршлагатай байна.
ЗТ-7.3 Бага хүчин чадлын цахилгаан эх үүсвэр, (бие даасан болон сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэр) түүнтэй холбогдох барилга байгууламжийн технологийн зураг төсөл	-Цахилгаан инженер-2	Цахилгаан инженерийн нэг нь цахилгаан хангамжийн зураг төслийн мэргэшсэн эсхүл зөвлөх зэрэгтэй байх Нөгөө инженер нь 3-с доошгүй жил ажилласан туршлагатай байна.
ЗТ-7.4 Мэдээлэл, харилцаа холбоо дохиоллын гол (магистраль) шугам сүлжээ, түүнтэй холбогдох барилга, байгууламжийн технологийн зураг төсөл	-Мэдээлэл, холбоо-дохиоллын инженер-2	Мэдээлэл, холбоо-дохиоллын инженерийн нэг нь барилга байгууламжийн мэдээлэл, холбоо-дохиоллын зураг төслийн мэргэшсэн эсхүл зөвлөх зэрэгтэй байх
ЗТ-8.1 заалтыг хассан.		

3.1.6. инженер геологийн зураг төсөл

Ажлын төрөл	Нөхцөл	Шаардлага
ЗТ-9.1 Инженер геологийн масштабын зураглал, А. Багаас өндөр төвөгшилтэй бүх төрлийн барилга байгууламжид зориулсан инженер-геологийн судалгаа (инженер-геологийн нөхцөл харгалзахгүй) Б. Өндөр болон онцгой төвөгшилтэй барилга байгууламжид зориулсан судалгааг инженер-геологийн энгийнээс дунд зэргийн нөхцөлтэй байршилд	-Инженер-геологийн инженер-1 -Геотехникийн инженер-1	Инженер-геологийн судалгааны зөвлөх инженерийн зэрэгтэй байх геологич /геотехник/ туршилтын мэргэшсэн зэрэгтэй байна.
-Инженер-геологич" мэргэжилд инженер-геологич, гидрогеологич, гео-экологич мэргэжлийн инженерүүд нэгэн адил хамрагдана.		

3.1.7.барилга байгууламжийн техник, эдийн засгийн үндэслэл, төсөв

Ажлын төрөл	Нөхцөл	Шаардлага
ЗТ-10.1 ТЭЗҮ /тухайн ажлын төрлийн хүрээнд/	- Эдийн засагч, санхүүгийн болон менежментийн чиглэлийн мэргэжилтэн-2 - Тухайн чиглэлийн инженер-2	Эдийн засагчийн аль нэг нь мэргэшлийн зэрэгтэй нөгөө нь ТЭЗҮ боловсруулж байсан ажлын туршлагатай байх Мэргэжлийн инженерийн нэг нь мэргэшсэн нөгөө нь зөвлөх зэрэгтэй байх
ЗТ-10.2 Барилга байгууламжийн ажлын төсөв	- Төсөвчин-2	Төсөв үнэлгээний мэргэжилтний аль нэг нь мэргэшсэн зэрэгтэй эсхүл тэргүүлэх зэрэгтэй байна.

3.1.8.Өргөх байгууламжийн эд анги үйлдвэрлэлийн зураг төсөл

Ажлын төрөл	Нөхцөл	Шаардлага
-------------	--------	-----------

PL

ЗТ-11.1 Машин, тоног төхөөрөмж, түүнийн эд ангийн үйлдвэрлэлийн зураг төсөл, кранаар ажил гүйцэтгэх зураг төсөл	-Механик инженер – 1 - Цахилгааны инженер -1	Механик инженер нь өргөн тээвэрлэх машин, барилгын машин, барилгын материалын үйлдвэрийн тоног төхөөрөмжийн аль нэгээр Зөвлөх зэрэгтэй байх
---	---	---

1.2. БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН УГСРАЛТ, ӨРГӨТГӨЛ, ШИНЭЧЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХҮРЭЭНД:

3.2.1. бага төвөгшилтэй барилга байгууламжийн угсралт, өргөтгөл, шинэчлэх ажил

Ажлын төрөл	Нөхцөл	Шаардлага
БА-2.1 Цутгамал болон угсармал төмөр бетон, мод ба өрөгт бүтээцэн барилгын угсралт, өргөтгөл, засвар шинэчлэлт, тохижилтын ажил гадна фасад ⁷	Барилгын инженер-1 ХАБЭА-1	Барилгын инженер нь мэргэжлээрээ 2-оос доошгүй жил ажилласан байх
БА-2.2 Усны барилга байгууламжийн угсралт, өргөтгөл, шинэчлэлийн ажил ⁸	Усны барилга байгууламжийн буюу усны нөөцийн инженер-1 ХАБЭА-н ажилтан-1	Усны барилга байгууламжийн инженер нь 5-с доошгүй жил ажилласан туршлагатай байх

3.2.2. Дунд, Өндөр төвөгшилтэй барилга байгууламжийн угсралт, өргөтгөл, шинэчлэлийн ажил.

*БА-3.1-БА-3.6-д хамаарагдах заалт нь БА-4.1-БА-4.6-р заалттай адил буюу өндөр төвөгшилтэй барилга байгууламжид хамаарна.

Ажлын төрөл	Нөхцөл	Шаардлага
БА-4.1 Цутгамал болон угсармал төмөр бетон арагт бүтээцэн болон иж бүрэн цутгамал бүтээцэн барилгын угсралт, өргөтгөл, засвар шинэчлэлт, тохижилтын ажил, гадна фасад ^{9 10}	-Барилгын инженер-2 -ХАБЭА-н ажилтан-2	Барилгын инженерийн аль нэг нь барилга байгууламжийн угсралт, засварын мэргэшсэн зэрэгтэй эсхүл зөвлөх зэрэгтэй байна. Аль нэг ХАБЭА-н аудитор байж болно.
БА-4.2 Усны барилга байгууламжийн угсралт, өргөтгөл, засвар шинэчлэлт, тохижилтын ажил ¹¹	-Усны барилга байгууламжийн буюу усны нөөцийн инженер-2	Усны барилга байгууламжийн инженерийн аль нэг нь усны барилга байгууламжийн угсралт засварын мэргэшсэн зэрэгтэй байх, нөгөө нь

⁷ Барилга байгууламжийн төвөгшлийн ангиллын төрөлд хамаарагдах орон сууц, төрөл бүрийн зориулалттай олон нийтийн барилга, сургуулийн өмнөх боловсролын байгууллага, сургууль, дотуур байр, эмнэлгийн, худалдаа, үйлчилгээний, үйлдвэрийн барилга байгууламж, агуулах, авто машины зогсоолын, цамхаг, тулгуур, түшиц хана түүнтэй адил байгууламж, хөдөө аж ахуйн зориулалттай барилга байгууламжуудын угсралт, өргөтгөл шинэчлэлийн ажлууд багтсан.

⁸ Барилга байгууламжийн төвөгшлийн ангилалд хамаарах 100 га хүртэлх усалтын систем, 100 мян.га хүртэлх усан мандлын талбайтай хөө цөөрмийн барилга байгууламж, 1000 м²/га хүртэлх барилгын нягттай хот суурингийн борооны ус зайлуулах систем, ХАА болон бэлчээр усжуулалтын уст цэгүүд, инженерийн хийцтэй усан оргилуурууд багтана.

⁹ Барилга байгууламжийн төвөгшлийн ангиллын төрөлд хамаарагдах орон сууц, төрөл бүрийн зориулалттай олон нийтийн барилга, сургуулийн өмнөх боловсролын байгууллага, сургууль, дотуур байр, эмнэлгийн, худалдаа, үйлчилгээний, үйлдвэрийн барилга байгууламж, агуулах, мэдээлэл, холбоо-сүлжээний барилга байгууламж, авто машины зогсоолын цамхаг, тулгуур, түшиц хана түүнтэй адил байгууламж, хөдөө аж ахуйн зориулалттай барилга байгууламжуудын угсралт, өргөтгөл, шинэчлэлийн ажлууд багтсан.

¹⁰ Тухайн заалтаар төвөгшлийн ангилалд хамаарахгүй гадна фасадны ажил, хамгаалалтын хашилт хаалтын ажлыг хийж болно

¹¹ Барилга байгууламжийн төвөгшлийн ангилалд хамаарах БНБД33-01-03-р тодорхойлогдох II ангийн усны үндсэн барилга байгууламжууд, II-IV ангийн усан цахилгаан станцын барилга, дулааны цахилгаан станцын усны барилга байгууламжууд

✓

	-ХАБЭА-н ажилтан-1	усны барилга байгууламжийн угсралт, засварын зөвлөх зэрэгтэй байх
БА-4.3 Ус хангамж, ариутгах татуургын системийн шугам сүлжээ, түүнтэй холбогдох барилга, байгууламжийн тоног төхөөрөмжийн угсралт	-Ус хангамж, ариутгах татуургын инженер-2 -ХАБЭА-н ажилтан-1	Ус хангамж, ариутгах татуургын инженер нь мэргэшсэн зэрэгтэй байх
БА-4.4 Дулааны гол (магистраль) шугам сүлжээ, түүний тоног төхөөрөмжийн угсралт	-Дулааны инженер-2 -ХАБЭА-н ажилтан-1	Дулааны инженер нь мэргэшсэн эсхүл зөвлөх зэрэгтэй байх
БА-4.5 Цахилгаан дамжуулах шугам сүлжээ, дэд станц, түүний тоног төхөөрөмжийн угсралт	-Цахилгаан инженер-2 -ХАБЭА-н ажилтан-1	Цахилгааны инженер нь мэргэшсэн эсхүл зөвлөх зэрэгтэй байх
БА-4.6 Газрын тосны барилга байгууламжийн угсралт, өргөтгөл, шинэчлэлийн ажил ¹²	-Газрын тос, газрын тосны бүтээгдэхүүн, хий хангамжийн барилга байгууламжийн инженер-2 -Газрын тосны хадгалалт тээвэрлэлтийн инженер-1 -Барилгын инженер-1 -ХАБЭА-н ажилтан-1	Газрын тос, газрын тосны бүтээгдэхүүн, хийн хангамжийн барилга байгууламжийн инженерийн аль нэг нь газрын тос, газрын тосны бүтээгдэхүүн, хийн хангамжийн барилга байгууламжийн мэргэшсэн зэрэгтэй байх, нөгөө нь газрын тос, газрын тосны бүтээгдэхүүн, хийн хангамжийн барилга байгууламжийн зөвлөх зэрэгтэй байх Барилгын инженер нь 5 жилээс доошгүй ажилласан байх
БА-4.7 Газар доорх гарц тусгай зориулалтын, бусад барилга байгууламжийн угсралт, өргөтгөл, шинэчлэлийн ажил	-Барилгын инженер-2 -Усны барилга байгууламжийн инженер-1 -Геодезийн инженер-1 -ХАБЭА-1	Барилгын инженерийн аль нэг нь барилга байгууламжийн угсралтын мэргэшсэн, эсхүл барилга байгууламжийн угсралтын зөвлөх зэрэгтэй байна. Усны барилга байгууламжийн болон геодезийн инженер нь 5-с доошгүй жил ажилласан туршлагатай байх
БА-4.8 Түүх, соёлын барилга байгууламжийн сэргээн засварлалт, угсралт, өргөтгөл, шинэчлэлийн ажил	-Барилгын инженер-2 -Архитектор-1 -ХАБЭА-1	Барилгын инженерийн аль нэг нь барилга байгууламжийн угсралтын мэргэшсэн, эсхүл барилга байгууламжийн угсралтын зөвлөх зэрэгтэй байна. Архитектор нь мэргэшсэн зэрэгтэй байх

3.2.3.Онцгой төвөгшилтэй барилга байгууламжийн угсралт, өргөтгөл, дотор инженерийн сүлжээний угсралт, шинэчлэлийн ажил.¹³

Ажлын төрөл	Нөхцөл	Шаардлага
БА-5.1 Цутгамал болон угсармал төмөр бетон арагт бүтээцэн барилга, түүний инженерийн	-Барилгын инженер-2 -УХАТ-ын инженер-1	Барилгын инженерийн аль нэг нь барилга байгууламжийн угсралтын мэргэшсэн, эсхүл барилга

мөн ангид хамаарах хаягдлын байгууламжууд (хөргөлтийн систем, үнсэн сав, эргэлтийн усны систем), 101м³/х дээш багтаамжтай ус татамжийн барилга байгууламжууд багтана.

¹² Барилга байгууламжийн төвөгшлийн ангиллын өндөр зэргийн төвөгшилтэй газрын тос, газрын тосны бүтээгдэхүүн, хийн барилга байгууламж (10000м³ хүртэл багтаамжтай газрын тос, газрын тосны бүтээгдэхүүн ачих, шилжүүлэх байгууламж, дамжуулах шугам, хийн цооногийн байгууламж, газрын тос, хий, ус цуглуулах, тээвэрлэх объектын барилга г.м)-ийн угсралтын ажлууд багтсан.

¹³ Онцгой төвөгшилт хамаарах заалтуудыг тухайн төсөлд олгохоор зохион байгуулна.

R

байгууламжийн угсралт, өргөтгөл, шинэчлэлтийн иж бүрэн ажил ¹⁴	- Дулаан хангамж, агаар сэлгэлтийн инженер-1 - Холбооны инженер-1 - Цахилгааны инженер-1 - Автоматжуулалтын инженер-1 - ХАБЭА /3-аас доошгүй хүнтэй/	байгууламжийн угсралтын зөвлөх зэрэгтэй байх Инженер хангамжийн инженерүүд нь тухайн чиглэлээр 3-с доошгүй жил ажилласан байх. <i>Зөвлөх үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдтэй гэрээ байгуулсан байна.</i>
БА-5.2 Усны барилга байгууламжийн угсралт, өргөтгөл, шинэчлэлийн ажил ¹⁵	- Усны барилга байгууламжийн инженер-2 - ХАБЭА-н ажилтан-2	Усны барилга байгууламжийн 2 инженер нь усны барилга байгууламжийн угсралт, засварын мэргэшсэн эсхүл 1 инженер нь усны барилга байгууламжийн угсралт засварын ажлын хүрээнд зөвлөх зэрэгтэй байх. <i>Зөвлөх үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдтэй гэрээ байгуулсан байна.</i>
БА-5.3-5.5 хасагдсан		
БА-5.6 Газрын тосны барилга байгууламжийн угсралт, өргөтгөл, шинэчлэлийн ажил ¹⁶	- Газрын тос, газрын тосны бүтээгдэхүүн, хий хангамжийн барилга байгууламжийн инженер-1 - Газрын тос, газрын тосны бүтээгдэхүүн, хий хангамжийн барилга байгууламжийн механик инженер-1 - Газрын тосны хадгалалт тээвэрлэлтийн инженер-1 - Барилгын инженер-1 - ХАБЭА-н ажилтан-1	Газрын тос, газрын тосны бүтээгдэхүүн, хийн хангамжийн барилга байгууламжийн инженерийн аль нэг нь газрын тос, газрын тосны бүтээгдэхүүн, хийн хангамжийн барилга байгууламжийн мэргэшсэн зэрэгтэй байх, нөгөө нь газрын тос, газрын тосны бүтээгдэхүүн, хийн хангамжийн барилга байгууламжийн зөвлөх зэрэгтэй механик инженер байх Барилгын инженер нь 5 жилээс доошгүй ажилласан байх <i>Зөвлөх үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдтэй гэрээ байгуулсан байна.</i>
БА-5.7 Газар доорх гарц тусгай зориулалтын, бусад барилга байгууламжийн угсралт, өргөтгөл, шинэчлэлийн ажил	- Барилгын инженер-2 - Усны барилга байгууламжийн инженер-2 - Геодезийн инженер-1 - ХАБЭА ажилтан /3-аас доошгүй хүнтэй/	Барилгын инженерийн нэг нь барилга байгууламжийн угсралтын мэргэшсэн, эсхүл зөвлөх зэрэгтэй байх Усны барилга байгууламжийн нэг инженер усны барилга байгууламжийн угсралт засварын мэргэшсэн байх. <i>Зөвлөх үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдтэй гэрээ байгуулсан байна.</i>

¹⁴ Барилга байгууламжийн төвөгшлийн ангиллын төрөлд хамаарагдах орон сууц, төрөл бүрийн зориулалттай олон нийтийн барилга, үйлдвэрийн барилга байгууламж, агуулах, авто машины зогсоолын цамхаг, тулгуур, түшиц хана түүнтэй адил байгууламжуудын угсралт, өргөтгөл, шинэчлэлийн ажлууд багтсан.

¹⁵ Барилга байгууламжийн төвөгшлийн ангилалд хамаарах БНБД 33-01-03-р тодорхойлогдох I ангийн усны үндсэн барилга байгууламжууд, I ангийн усан цахилгаан станцын барилга, атомын цахилгаан станцын усны барилга байгууламжууд (хөргөлтийн систем, үнсэн сан, эргэлтийн усны систем) багтана.

¹⁶ Барилга байгууламжийн төвөгшлийн ангиллын өндөр зэргийн төвөгшилтэй газрын тос, газрын тосны бүтээгдэхүүн, хийн барилга байгууламж, (10001м³-ээс дээш хүртэл багтаамжтай газрын тос, газрын тосны бүтээгдэхүүн ачих, шилжүүлэх байгууламж, дамжуулах шугам, хийн цооногийн байгууламж, гарын тос, хий, ус цуглуулах, тээвэрлэх объектын барилга г.м)-ийн угсралтын ажлууд багтсан.

3.2.4. Бага, дунд, өндөр төвөгшилтэй барилга байгууламжийн дотор инженерийн шугам, сүлжээний угсралт, өргөтгөл, шинэчлэлийн ажил

Ажлын төрөл	Нөхцөл	Шаардлага
БА-6.1 Барилга байгууламжийн дотор ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээ, тэдгээрийн тоног төхөөрөмж, гадна салбар шугам сүлжээний угсралт	-Ус хангамж, ариутгах татуургын инженер-1 -ХАБЭА-1	Ус хангамж, ариутгах татуургын инженер нь мэргэжлээрээ 3-аас доошгүй жил ажилласан байх
БА-6.2 Барилга байгууламжийн дотор халаалт, салхивчийн шугам сүлжээ, Хөргөх байгууламж тэдгээрийн тоног төхөөрөмж, гадна салбар шугам сүлжээний угсралт	-Халаалт агаар сэлгэлтийн инженер-1 -ХАБЭА-1	Халаалт агаар сэлгэлтийн инженер нь мэргэжлээрээ 3-аас доошгүй жил ажилласан байх
БА-6.3 Барилга байгууламжийн дотор гэрэлтүүлэг, цахилгаан хангамжийн угсралт, тэдгээрийн тоног төхөөрөмж, тухайн барилгын гадна салбар шугам сүлжээний угсралт	-Цахилгааны инженер-1 -ХАБЭА-1	Цахилгааны инженер нь мэргэжлээрээ 3-аас доошгүй жил ажилласан байх
БА-6.4 Барилга байгууламжийн дотор холбоо дохиолол, интернэт сүлжээ, гал унтраах болон галын аюулын дохиоллын системийн угсралт, тэдгээрийн тоног төхөөрөмж, тухайн барилгын гадна салбар шугам сүлжээний угсралт	-Холбоо дохиолол, мэдээллийн инженер-1 -ХАБЭА-1	Холбоо дохиолол, мэдээллийн инженер нь мэргэжлээрээ 3-аас доошгүй жил ажилласан байх

3.3. ӨРГӨХ БАЙГУУЛАМЖ, ТҮҮНИЙ ЭД АНГИЙН ҮЙЛДВЭРЛЭЛ,УГСРАЛТ, ЗАСВАР ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХҮРЭЭНД:

3.3.1 Дунд, өндөр, онцгой төвөгшилтэй барилга байгууламжид хамаарах өргөх байгууламж

Ажлын төрөл	Нөхцөл	Шаардлага
ӨБ-4.1 Лифт, эскалатор, зорчигчийн ган татлагат болон чирэх замын угсралтын ажил, засвар, техникийн үйлчилгээ	Механик инженер-1 Цахилгааны инженер-1 Лифтний засварын механик-2 ХАБЭА-1	Механик инженер нь өргөн тээвэрлэх машин, барилгын машин, барилгын материалын үйлдвэрийн тоног төхөөрөмжийн чиглэлийн аль нэгээр мэргэшсэн зэрэгтэй байх
ӨБ-4.2 Ачаа өргөх кран, төрөл бүрийн өргүүрийн (Барилгын өргүүр, манипулятор кран, сагстай өргөгч) угсралтын ажил, засвар, техникийн үйлчилгээ ¹⁷	Механик инженер-1 Цахилгааны инженер-1 Краны засварын механик-2 ХАБЭА-1	Механик инженер нь өргөн тээвэрлэх машин, барилгын машин, барилгын материалын үйлдвэрийн тоног төхөөрөмжийн чиглэлийн аль нэгээр мэргэшсэн зэрэгтэй байх
ӨБ-4.3 Барилгын дүүжин болон тавцант өргүүрийн угсралтын ажил, засвар, техникийн үйлчилгээ ¹⁸	Механик инженер-1 Өргүүрийн засварын механик-2 ХАБЭА-1	Механик инженер нь өргөх, тээвэрлэх машин, барилгын машин тоног төхөөрөмжийн ашиглалтын чиглэлийн инженер байх..

¹⁸ Барилгын дүүжинт болон тавцант өргүүр,

3.3.2. өргөх байгууламж түүний эд ангийн үйлдвэрлэл

Ажлын төрөл	Нөхцөл	Шаардлага
ӨБ-4.4 Өргөх байгууламжийн үйлдвэрлэл	Механик инженер-1 Цахилгааны эсвэл Автоматжуулалтын инженер-1 ХАБЭА-1	Механик инженер нь өргөн тээвэрлэх машин, барилгын машин, барилгын материалын үйлдвэрийн тоног төхөөрөмжийн чиглэлийн аль нэгээр Зөвлөх зэрэгтэй байх

3.4.БАРИЛГЫН МАТЕРИАЛ ҮЙЛДВЭРЛЭЛ ЭРХЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХҮРЭЭНД:

3.4.1. Цемент, чулуунцар зэрэг үйлдвэрлэл

Ажлын төрөл	Нөхцөл, шаардлага
МҮ-1.1.1 Технологийн иж бүрэн дамжлага бүхий цементийн үйлдвэр	100 мян.тн хүртэл жилийн хүч чадалтай, тохирлын гэрчилгээ
МҮ-1.1.2 Технологийн иж бүрэн дамжлага бүхий цементийн үйлдвэр	100-500 мян.тн жилийн хүч чадалтай, тохирлын гэрчилгээ
МҮ-1.1.3 Технологийн иж бүрэн дамжлага бүхий цементийн үйлдвэр	500 мян.тн дээш жилийн хүч чадалтай, тохирлын гэрчилгээ
МҮ-1.2.1 Чулуунцар тээрэмдэх шугам бүхий цементийн үйлдвэр	50 мян.тн хүртэл жилийн хүч чадалтай, тохирлын гэрчилгээ
МҮ-1.2.2 Чулуунцар тээрэмдэх шугам бүхий цементийн үйлдвэр	50- мян.тн дээш жилийн хүч чадалтай, тохирлын гэрчилгээ
МҮ-1.3.1 Шохой, магни, гөлтгөнө болон холимог барьцалдуулагч бүхий материалын үйлдвэр	50- мян.тн хүртэл жилийн хүч чадалтай, тохирлын гэрчилгээ
МҮ-1.3.2 Шохой, магни, гөлтгөнө болон холимог барьцалдуулагч бүхий материалын үйлдвэр	50- мян.тн дээш жилийн хүч чадалтай, тохирлын гэрчилгээ

3.4.2. Дүүргэгч материал, бүтээгдэхүүний үйлдвэрлэл

Ажлын төрөл	Нөхцөл, шаардлага
МҮ-2.1.1 Дүүргэгч материал элс, хайрга, дайрга, галт уулын гаралтай чулуу бутлан ангилах , байгалийн чулуу олборлох, боловсруулах үйлдвэр	100 мян.м³ хүртэл хүч чадалтай, тохирлын гэрчилгээ
МҮ-2.1.2 Дүүргэгч материал элс, хайрга, дайрга, галт уулын гаралтай чулуу бутлан ангилах , байгалийн чулуу олборлох, боловсруулах үйлдвэр	100 мян.м³ дээш хүч чадалтай, тохирлын гэрчилгээ

3.4.3. Дулаан, дуу тусгаарлагч материалын үйлдвэрлэл

Ажлын төрөл	Нөхцөл, шаардлага
МҮ-3.1.1 Эрдэс /чулуун/ хөвөн материалын үйлдвэр	60 мян.м³ хүртэл жилийн хүч чадалтай, тохирлын гэрчилгээ
МҮ-3.1.2 Эрдэс /чулуун/ хөвөн материалын үйлдвэр	60 мян.м³ дээш жилийн хүч чадалтай, тохирлын гэрчилгээ
МҮ-3.2.1 Хөнгөн ба сүвэрхэг дүүргэгч материалын үйлдвэр	40 мян.м³ жилийн хүч чадалтай, тохирлын гэрчилгээ
МҮ-3.3 Хөөсөн полистрол хавтан, эдлэлийн үйлдвэр /EPS, EPP, EPE, Neopor, XPS, XPE, PUR төрлийн дуу, дулаан тусгаарлах материалын үйлдвэр, тохирлын гэрчилгээ	
МҮ-3.4 Полиуретан /PUR/ шүршдэг болон цутгадаг хөөс, скорлуп, гулдмай хавтан, авдаггүй хэв, бусад эдлэлийн үйлдвэр, тохирлын гэрчилгээ	
МҮ-3.5 Сендвич хавтангийн үйлдвэр, тохирлын гэрчилгээ	

МУ-3.6 Автоклавын хөнгөн бетон бүтээгдэхүүний үйлдвэр	
МУ-3.7 Байгалийн болон зохиомол хөнгөн дүүргэгч бүхий дуу, дулаан тусгаарлагч гулдмай, хавтгаалжийн үйлдвэр	20 мян.м3 хүртэл хүч чадалтай, тохирлын гэрчилгээ
МУ-3.8 Байгалийн болон зохиомол хөнгөн дүүргэгч бүхий дуу, дулаан тусгаарлагч гулдмай, хавтгаалжийн үйлдвэр	20 мян.м3 дээш хүч хүчин чадалтай, тохирлын гэрчилгээ

3.4.4. Бетон, төмөр бетон эдлэл, бетон зуурмагийн үйлдвэрлэл

Ажлын төрөл	Нөхцөл, шаардлага
МУ-4.1.1 Бетон зуурмагийн үйлдвэр бүхий төмөр бетон эдлэлийн үйлдвэр	20 мян.м3 хүртэл жилийн хүч чадалтай, тохирлын гэрчилгээ
МУ-4.2.2 Бетон зуурмагийн үйлдвэр	20 мян.м3-с дээш жилийн хүч чадалтай, тохирлын гэрчилгээ

3.4.5. Ган туйван, металл хийц эдлэлийн үйлдвэрлэл

Ажлын төрөл	Нөхцөл, шаардлага
МУ-5.1.1 Ган туйван, бетон бүтээцийн мяндас полимер арматур, катангийн үйлдвэр	50 мян.тн хүртэл жилд хүч чадалтай, тохирлын гэрчилгээ
МУ-5.1.2 Ган туйван, бетон бүтээцийн мяндас полимер арматур, катангийн үйлдвэр	50 мян.тн дээш жилд хүчин чадалтай, тохирлын гэрчилгээ
МУ-5.3.1 Даацын металл хийц эдлэл, бүтээц, тоног төхөөрөмжийн сэлбэг, эд анги, хийцийн үйлдвэр	10 мян.тн хүртэл жилд хүч чадалтай, тохирлын гэрчилгээ
МУ-5.3.2 Даацын металл хийц эдлэл, бүтээц, тоног төхөөрөмжийн сэлбэг, эд анги, хийцийн үйлдвэр	10 мян.тн дээш жилд хүч чадалтай, тохирлын гэрчилгээ

3.4.6. Барилгын хуванцар хоолой бусад материал, хийц эдлэлийн үйлдвэрлэл

Ажлын төрөл	Нөхцөл, шаардлага
МУ-6.1.1 Барилгын бүх төрлийн хуванцар хоолой, холбох хэрэгсэл, систем тулаас, пум, саукуд бусад хэрэгслэлийн үйлдвэр, тохирлын гэрчилгээ	

3.4.7. Барилгын химийн материалын үйлдвэрлэл

Ажлын төрөл	Нөхцөл, шаардлага
МУ-7.1 Бетоны болон химийн идэвхит эрдэс нэмэлтийн үйлдвэр, тохирлын гэрчилгээ	

3.4.8. Керамик материал, бүтээгдэхүүн үйлдвэрлэл

Ажлын төрөл	Нөхцөл, шаардлага
МУ-8.1.1 Керамик тоосго, гулдмайн үйлдвэр, тохирлын гэрчилгээ	
МУ-8.2.1 Дээврийн вааран керамик хавтанцар, галд тэсвэртэй эдлэлийн үйлдвэр, тохирлын гэрчилгээ	

3.4.9. Дээврийн материал үйлдвэрлэх үйл ажиллагааны хүрээнд:

Ажлын төрөл	Нөхцөл, шаардлага
МУ-9.1 Дээврийн хуйлмал, зүймэл /металл, металл бус, бетон, Нано технологийн, / материалын үйлдвэр, тохирлын гэрчилгээ	

Handwritten signature

3.4.10. Шалны материал үйлдвэрлэх үйл ажиллагааны хүрээнд:

Ажлын төрөл	Нөхцөл, шаардлага
МУ-10.1 Шалны бүх төрлийн материалын үйлдвэр, тохирлын гэрчилгээ	


3.4.11.. Цонх хаалга үйлдвэрлэх үйл ажиллагааны хүрээнд

Ажлын төрөл	Нөхцөл, шаардлага
МУ-11.1.1 Барилгын Цонх, хаалга, үйлдвэрлэл, тохирлын гэрчилгээ	
МУ-11.1.2 Хуванцар бэлдэц цувимал үйлдвэрлэл, тохирлын гэрчилгээ	
МУ-11.1.3 Эрчим хүчний хэмнэлттэй шилэн багцын үйлдвэрлэл, тохирлын гэрчилгээ	
МУ-11.1.4 Барилгын шилэн фасад, тохирлын гэрчилгээ	

----- оОо -----

К

Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилгын ажил гүйцэтгэх, барилгын материалын үйлдвэрлэл, өргөх байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл, угсралт, засвар үйлчилгээний тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагын 1 дүгээр хавсралт



**БАРИЛГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АСУУДЛЫГ
ГЭРЭЭНИЙ ҮНДСЭН ДЭЭР ХАРИУЦАГЧ, ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ЭЗЭМШИГЧ
НАРЫН ХООРОНД БАЙГУУЛСАН ГЭРЭЭНИЙ ЗАГВАР**

20... оны .. дугаар сарын...-ны өдөр

Дугаар:.....

Улаанбаатар хот

Нэг. Ерөнхий зүйл

1.1. Монгол Улсын нутаг дэвсгэр дээр зураг төсөл боловсруулах, барилгын ажил, өргөх байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл, угсралт, засвар үйлчилгээ эрхлэхээр барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл авсан (цаашид "БҮАТЗ эзэмшигч" гэнэ) аж ахуйн нэгж, байгууллага (цаашид "ААНБ" гэнэ) бүр нь.....(цаашид "БҮАТЗ олгогч" гэнэ)-тай энэхүү гэрээг байгуулж ажиллана.

1.2. Хоёр тал нь Зөвшөөрлийн тухай хууль, Барилгын тухай хууль, Хот суурины усан хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль болон бусад холбогдох тогтоомжийн хүрээнд энэхүү гэрээг байгуулж, хууль тогтоомжид заагдсан эрх, үүргийг хүлээнэ.

1.3. Гэрээний үндсэн зорилго нь тусгай зөвшөөрөл олгогч, эзэмшигч хоёр тал нь хууль эрх зүйн хүрээнд хүлээсэн үүрэг хариуцлагыг хамтран хэрэгжүүлэхэд оршино.

1.4. БҮАТЗ олгогчийг төлөөлж:
...../Байгууллагын нэр/
..... /албан тушаал/
..... овог нэр.....;

1.5. БҮАТЗ эзэмшигчийг төлөөлж: "....."ХХК-ийн
...../албан тушаал/.....овогтой
..... нар нь
.....

..... Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын 20...оны дугаар сарын ...-ны өдрийн дугаар тушаалыг үндэслэн энэхүү гэрээг байгуулав.

Хоёр. БҮАТЗ олгогчийн эрх, үүрэг

2.1. Барилгын салбарт нийтлэг мөрдөх хууль тогтоомж, журам, заавар, зэрэг тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн үйл ажиллагаанд мөрдөх эрх зүйн акт, норм норматив, техникийн баримт бичгүүдийн талаарх мэдээ, мэдээллээр шуурхай хангаж ажиллах;

10

2.2.БҮАТЗ эзэмшигчийн нөхцөл шаардлагатай холбогдох мэдээ, тайлан Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.3-т заасны жил бүрийн эхний улиралд багтаан хүлээн авч нэгтгэн, дүн шинжилгээ хийж, боловсруулан Барилын үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллагад хүргүүлэх;

2.3.Барилгын салбарын норм, дүрэм, заавар, стандартыг шинэчлэн боловсруулж, баталгаажуулах ажлыг зохион байгуулж, хэрэгжүүлэх, норм нормативын баримт бичгийг боловсруулахад зарцуулах хөрөнгийг төвлөрүүлэх;

2.4.Барилгын салбарын мэргэжилгүй БҮАТЗ эзэмшигчийн гүйцэтгэх удирдлагад барилгын үйл ажиллагааны талаар мэдлэг олгох сургалтыг зохион байгуулах, инженер, техникийн ажилчдыг мэргэжил дээшлүүлэх, гадаад, дотоодын ижил төстэй ажил, үйлчилгээ эрхэлдэг байгууллагуудын туршлагыг судлах, дадлага хийх, үзэсгэлэн, семинар, зөвлөгөөнийг зохион байгуулах, үйл ажиллагаагаа өргөтгөхөд мэргэжлийн туслалцаа дэмжлэгийг үзүүлэх;

2.5.БҮАТЗ эзэмшигчийн ирүүлсэн албан бичгийг үндэслэн инженер, техникийн ажилтнууд (цаашид "ИТА")-ын шилжилт хөдөлгөөнийг мэдээллийн санд бүртгэх;

2.6.Мэргэжлийн хяналтын байгууллага, иргэдийн мэдээллийн дагуу илэрсэн зөрчил, дутагдлыг мэдээллийн нэгдсэн сангийн "Тусгай бүртгэл"-д бүртгэх, энэ талаар тухайн ААНБ-дад албан бичгээр мэдэгдэх, зөрчлийг арилгах талаар хийсэн ажлын үр дүнг харгалзан бүртгэлээс хасах, тендерийн хороо, үнэлгээний хэсэгт энэ талаар мэдээллийг өгөх;

2.7.Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох асуудлыг ажлын албаар шийдвэрлүүлэн, харьяалах татварын алба, хяналтын асуудал хариуцсан байгууллагуудад мэдэгдэж, нийтэд мэдээлэх.

БҮАТЗ эзэмшигч байгууллагын үйл ажиллагаанд үзлэг шалгалт хийж, удирдамж, чиглэлийг өгөх;

2.8.БҮАТЗ эзэмшигчийн тусгай зөвшөөрлийг Зөвшөөрлийн тухай хуулийн 6.1 дүгээр зүйлд заасныг дагуу барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, сэргээх саналыг тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий этгээдэд холбогдох баримтын хамтаар хүргүүлж, шийдвэрлүүлэх

2.9.БҮАТЗ эзэмшигчийн тусгай зөвшөөрлийг Зөвшөөрлийн тухай хуулийн 6.2 дугаар зүйлд заасан үндэслэлээр хүчингүй болгох саналыг тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий этгээдэд холбогдох баримтын хамтаар хүргүүлж, шийдвэрлүүлэх;

2.10.БҮАТЗ эзэмшигч нь инженер, техникийн ажилчдын шилжилт хөдөлгөөний нөхөн бүрдүүлэлтийг 90 хоногт багтаан хийгээгүй тохиолдолд барилгын үйл ажиллагааны зөвшөөрлийг түдгэлзүүлэх, эсхүл нь тусгай зөвшөөрөлд заагдаагүй төрлийн үйл ажиллагаа эрхэлсэн, эсхүл барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн хугацаанд үйл ажиллагаа явуулсан нь холбогдох төрийн хяналт, шалгалт хэрэгжүүлэгч байгууллагын эрх бүхий албан тушаалтны шалгалтаар тогтоогдсон бол Зөвшөөрлийн тухай хуулийн 6.2 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.4 дэх заалтад заасан үндэслэлээр тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох саналыг тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий этгээдэд холбогдох баримтын хамтаар хүргүүлж, шийдвэрлүүлэх;

2.11.БҮАТЗ эзэмшигч нь Барилгын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.9-д заасан хугацаанд үйл ажиллагааны мэдээ тайланг энэ гэрээний 3.2-т заасан маягтын дагуу ирүүлээгүй бол Зөвшөөрлийн тухай хуулийн 6.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1.2 дахь заалтад заасан үндэслэлээр тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх саналыг тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий этгээдэд холбогдох баримтын хамтаар хүргүүлж, шийдвэрлүүлэх;

Гурав. Барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл эзэмшигчийн эрх, үүрэг

3.1.БҮАТЗ-ийн нөхцөл шаардлагыг хангаж, олгогдсон хүрээнд заасан ажил, үйлчилгээг эрхлэх;

3.2.Барилгын салбарын мэргэжилгүй БҮАТЗ эзэмшигчийн гүйцэтгэх удирдлага нь энэ гэрээий 2.4-т заасан 1 багц сургалтад хамрагдсан байна.

3.3.Барилга, хот байгуулалтын сайд, Үндэсний статистикийн хорооны даргын хамтарсан 2019 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 206, А/184 дугаартай тушаалаар батлагдсан барилгын салбарын бүртгэл, мэдээллийн маягтаар барилгын үйл ажиллагааны тайлан мэдээг жилд 2 удаа буюу хагас жилийн байдлаар тухайн оны 07 дугаар сарын 20-ны өдрийн дотор, жилийн эцсийн байдлаар дараа оны 02 дугаар сарын 20-ны өдрийн дотор www.mcis.gov.mn цахим системээр ирүүлнэ. (үйл ажиллагаа явуулаагүй бол үйл ажиллагааны тайланг "Х" –ээр ирүүлнэ).

3.4.БҮАТЗ эзэмшигч, удирдлага, ерөнхий болон талбайн инженер, даамал зэрэг удирдах гол мэргэжилтнүүд нь ажлаас чөлөөлөгдөх, суурин утас, факс, и-мэйл хаяг, шуудангийн хаяг өөрчлөгдвөл энэ тухайгаа БҮАТЗ олгогчид нэн даруй мэдэгдэх;

3.5.Барилгын тухай хууль болон "Барилгын норм, норматив боловсруулах санг бүрдүүлэх, зарцуулах журам"-д заасны дагуу Норм, нормативын санд төвлөрүүлэх хөрөнгийг улирал бүрийн дараа сарын 15-ны дотор "Барилгын хөгжлийн төв" ТӨААТҮГ-ын Худалдаа хөгжлийн банкны 26 000 78 533 тоот дансанд шилжүүлэх;

3.6.БҮАТЗ эзэмшигч нь "БҮАТЗ"-ийг авснаас хойш ажлын 7 хоногийн дотор харьяалагдах татварын албанд эрхлэх үйл ажиллагааны чиглэлээ бүртгүүлсэн байх;

3.7.БҮАТЗ-д заасан ажил, үйлчилгээг гүйцэтгэхэд шаардлагатай норм, дүрэм, стандарт, журам, заавар, альбом, каталог, хууль тогтоомж, дүрэм журмын эмхэтгэл зэрэг техникийн баримт бичгүүдийн фондыг тогтмол баяжуулах;

3.8.Ажиллагсадтай хөдөлмөрийн гэрээг байгуулахдаа хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн (цаашид "ХАБЭА" гэнэ) нөхцөлийн талаарх заалтыг тусгаж, мөрдөх (ажил олгогч, ажил гүйцэтгэгч нарын хөдөлмөр хамгааллын талаар харилцан хүлээх эрх, үүргийг тодорхой тусгах), аюулгүй ажиллагааг хангаж ажиллах;

3.9.Барилгын үйлдвэрлэлд ашиглаж байгаа тоног төхөөрөмж, машин механизмын аюулгүй ажиллагааг бүрэн хангаж хариуцан ажиллах;

3.10. Үйлдвэрлэл, үйлчилгээгээ холбогдох хууль тогтоомжийн хүрээнд барилгын норм, дүрэм стандартыг мөрдөн чанартай явуулах бөгөөд хэрэглэгчдийн эрх ашгийг хохироохгүй байх;

3.11. БҮАТЗ олгогч байгууллагатай байнгын холбоотой байж, БҮАТЗ олгогчоос зохион байгуулж буй бүхий л үйл ажиллагаанд идэвхтэй оролцож, инженер, техникийн ажилтнуудаа бүрэн хамруулж мэргэжлийн ур чадварыг нь байнга дээшлүүлж байх;

3.12. Ажил, үйлчилгээг гүйцэтгэхдээ тогтмол хяналт шалгалт хийх нэгж, эсхүл албан тушаалтан ажиллуулах, хяналт шалгалт хийх эрх бүхий байгууллагаар хянуулж, дүгэлт гаргуулж ажиллах;

3.13. Хөдөлмөрийн тухай хууль болон Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2008 оны 107 дугаар тушаалаар баталсан Насанд хүрээгүй хүн ажиллахыг хориглосон ажлын байрны жагсаалт тус бүрийг мөрдлөг болгож насанд хүрээгүй хүүхэд ажиллуулахгүй байх.

Дөрөв. Тусгай зөвшөөрлийн гэрээний хариуцлага

4.1. Иргэн, хуулийн этгээд зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгохтой холбоотой гомдлыг Зөршөөрлийн тухай хуулийн 9.4 дүгээр зүйлд заасан журмын дагуу гаргаж шийдвэрлүүлнэ.

4.2. БҮАТЗ-ийн Гэрээг байгуулсан хоёр талын аль нэгийн санаачилгаар гэрээг цуцлах болбол 14- оос доошгүй хоногийн өмнө нөгөө талдаа мэдэгдэнэ.

4.3. БҮАТЗ-ийн Гэрээ нь БҮАТЗ-ийн Гэрчилгээний хамт хүчин төгөлдөр байх бөгөөд зөвшөөрөл олгогдсон, сунгагдсан өдрөөс эхлэн 5 (таван) жилийн хугацаанд хүчинтэй байна. БҮАТЗ нь цуцлагдсан, түдгэлзүүлсэн шийдвэр гарсан өдрөөс эхлэн гэрээг хүчингүй болсонд тооцно.

Тав. Гэрээний тусгай тэмдэглэл

5.1. Тушаалаар олгогдсон ажлын төрлийн заалт:

5.2. Эзэмшигчийн байршил, хаяг:

.....
.....

Утас:.....Факс:.....Е-майл
хаяг:.....

Гэрээ байгуулсан:

Хариуцагч:



Зөвшөөрөл эзэмшигч



12

Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилгын ажил гүйцэтгэх, барилгын материалын үйлдвэрлэл, өргөх байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл, угсралт, засвар үйлчилгээний тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагын 2 дугаар хавсралт



ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЧИЛГЭЭНИЙ ЗАГВАР, ТОДОРХОЙЛОЛТ

1. “Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилгын ажил гүйцэтгэх, барилгын материалын үйлдвэрлэл, өргөх байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл, угсралт, засвар үйлчилгээ эрхлэх этгээдэд олгох тусгай зөвшөөрлийн гэрчилгээ /цаашид “гэрчилгээ” гэх/-ний загварыг тодорхойлов.

2. Тусгай зөвшөөрлийн гэрчилгээ нь Зөвшөөрлийн тухай хуулийн 5.4 дүгээр зүйлд заасныг тусгасан байна. Тусгай зөвшөөрлийн гэрчилгээг бусдад худалдах, бэлэглэх, барьцаалах зэргээр шилжүүлж үл болно.

3. Тусгай зөвшөөрлийн гэрчилгээ нь 4 шатлал бүхий нууцлалтай, үнэт цаас байна.

4. Гэрчилгээний загварыг тодорхойлоход хавсаргав.

ГЭРЧИЛГЭЭНИЙ НҮҮРЭН ТАЛ, АГУУЛГА

5. Гэрчилгээний өргөн нь 22 см, урт нь 30 см 5 мм байна.

6. Гэрчилгээний дэвсгэр С-51%, М-2%, Y-7%, К-0% кодын цэнхэр өнгөтэй байх ба 11 мм-ийн өргөнтэй С-100%, М-52%, Y-20%, К-31% кодын цайвар цэнхэр өнгийн сүлжмэл хээн хүрээтэй байна.

7. Гэрчилгээний дээд хэсэгт 22.5x45 мм хэмжээтэй соёмбыг байрлуулна. Соёмбо нь MNS6262:2011 стандартад заасан шаардлагыг хангасан байна.

8. Соёмбын хажуу талд Тусгай зөвшөөрлийн гэрчилгээний дугаар байна.

9. Тусгай зөвшөөрлийн гэрчилгээний дугаарыг 7-н оронтой /00-000/00/ тоогоор тэмдэглэж, ангилал, кодыг оруулах ба 00- аймаг, дүүргийн код, 000- тухайн жилд олгогдож буй тусгай зөвшөөрлийн дугаар, 00- тусгай зөвшөөрөл олгогдсон оныг илэрхийлнэ.

10. Соёмбын доод талд тусгай зөвшөөрөл олгосон Барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын нэрсийг С-100%, М-52%, Y-20%, К-31% кодын хөх өнгөөр, том үсгээр (Arial bold, үсгийн хэмжээ 24) бичсэн байна.

11. Барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын нэрийн доод талд, С-51%, М-2%, Y-7%, К-0% кодын хөх өнгөөр том үсгээр (Arial bold, үсгийн хэмжээ 96) “**ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ**” гэсэн гарчиг байх ба түүний доод талд тусгай зөвшөөрлийн дугаарыг бичнэ.

Handwritten signature

12. Аж ахуйн үйл ажиллагааны төрлийг товчлол үсгээр илэрхийлж “БУ”- Барилга угсралт, “ЗТ”- Зураг төсөл, “ӨБ”- Өргөх байгууламж гэсэн утгаар ойлгож тусгай зөвшөөрлийн дугаарын эхэнд бичнэ.

13. Гэрчилгээ нь “Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай” хуулийг үндэслэнаймаг /нийслэл/-ийнсум /дүүрэг/-ийн-дажил, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийгоныдугаар сарын-ны өдрөөсжилийн хугацаатай олгов. “Тусгай зөвшөөрөл нь хавсралт болон гэрээний хамт хүчинтэй” гэсэн өгүүлбэр бүхий бичвэртэй байна.

14. Гэрчилгээний доод талд гэрчилгээ олгосон Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын нэр, олгосон огноо, олгосон газрыг бичсэн байна.

ГЭРЧИЛГЭЭНИЙ АР ТАЛ, АГУУЛГА

15. Гэрчилгээний дээд хэсэгт “Ажил үйлчилгээний төрөл:” гэснийг жижиг үсгээр, доод хэсэгт Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хаяг.....Компанийн захирал /эзэн/.....
.....Утас:.....Факс:.....Е-mail:..... өгүүлбэр бүхий бичвэртэй байна.

ГЭРЧИЛГЭЭНИЙ ХАВСРАЛТЫН НҮҮРЭН ТАЛ, АГУУЛГА

16. Гэрчилгээ нь хавсралттай байх бөгөөд хавсралт нь гэрчилгээний салшгүй хэсэг байна.

17. Хавсралтын баруун дээд талд “Гэрчилгээний хамт хүчинтэй” гэсэн бичиглэл, түүний доод талд “ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЧИЛГЭЭНИЙ ХАВСРАЛТ” гэсэн гарчиг, түүний доод талд “Нэмэлт өөрчлөлт” гэсэн бичвэр бичигдэнэ.

18. Хавсралтын доод талд баталгаажуулсан Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын нэр, нэмэлт өөрчлөлтийг оруулсан “огноо”-г оруулна.

ГЭРЧИЛГЭЭНИЙ ХАВСРАЛТЫН АР ТАЛ, АГУУЛГА

19. Хавсралтын дээд талд Барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын нэр, түүний доод талд Барилгын тухай хуулийн 34.1-д заасан байгууллагын нэр, түүний доод талд тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй байгуулсан гэрээг жил бүр дүгнэсэн тухай тэмдэглэл, гэрээ дүгнэсэн албан тушаалтны гарын үсэг, байгууллагын тэмдэгийг дарах зориулалттай хүснэгт байх ба гэрээ дүгнэсэн огноо, тэмдэглэгээ хийсэн албан тушаалтны нэр, баталгаажуулсан “тэмдэг”-ийг дарсан байна.

----oOo----

62

ХОТ БАЙГУУЛАЛТ, БАРИЛГА, ОРОН СУУЦЖУУЛАЛТЫН ЯАМ

ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ

ТУСГАЙ	ЗӨВШӨӨРЛИЙН	ҮНДСЭН
МЭДЭЭЛЭЛ:.....		
.....		

Гарын үсэг





0000749

ХОТ БАЙГУУЛАЛТ, БАРИЛГА, ОРОН СУУЦЖУУЛАЛТЫН ЯАМ
ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ

Дугаар...

"Зөвшөөрлийн тухай" Монгол Улсын хуулийг үндэслэн

..... аймаг/нийслэлийн

..... сум/дүүргийн

..... -д

.....
/улсын бүртгэлийн дугаар/

.....
/регистрийн дугаар/

..... ажил, үйлчилгээ эрхлэх тусгай
зөвшөөрлийг оны -р сарын -ны өдрөөс
жилийн хугацаатай олгов.

Тусгай зөвшөөрөл нь хавсралт болон гэрээний хамт хүчинтэй.

ХОТ БАЙГУУЛАЛТ,
БАРИЛГА, ОРОН
СУУЦЖУУЛАЛТЫН САЙД

Ж.БАТСУУРЬ

..... он сар өдөр

Улаанбаатар хот

Ажил, үйлчилгээний төрөл:

Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хаяг:

Компанийн захирал /эзэн/ /овог, нэр/

Утас: Факс: И-мэйл:

100

..... дугаар гэрчилгээний хавсралт
Гэрчилгээний хамт хүчинтэй.

ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЧИЛГЭЭНИЙ ХАВСРАЛТ

Нэмэлт, өөрчлөлт:

14

Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилгын ажил гүйцэтгэх, барилгын материалын үйлдвэрлэл, өргөх байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл, угсралт, засвар үйлчилгээний тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагын 3 дугаар хавсралт



БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЗУРАГ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ, БАРИЛГЫН АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ, БАРИЛГЫН МАТЕРИАЛЫН ҮЙЛДВЭРЛЭЛ, ӨРГӨХ БАЙГУУЛАМЖ, ТҮҮНИЙ ЭД АНГИЙН ҮЙЛДВЭРЛЭЛ, УГСРАЛТ, ЗАСВАР ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭХ ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД ТАВИХ ХЯНАЛТ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХӨЛСНИЙ ХЭМЖЭЭ

1. Барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл олгох үйлчилгээний суурь хөлсний хэмжээг 420,000 /дөрвөн зуун хорин мянган/ төгрөг байна.

2. Үйл ажиллагаа эрхлэх ажлын төрлөөс хамаарсан нэмэлт хөлсийг дараах байдлаар тогтоож, тусгай зөвшөөрөл шинээр авах, сунгалт хийлгэх, нэмэлт ажлын төрөл авах тохиолдолд дараах байдлаар тогтооно.

Д/д	Барилга байгууламжийн төвөгшлийн ангилал болон хүчин чадлын төрөл	Үйлчилгээний нэмэлт хөлсний хэмжээ /төгрөгөөр/
Нэг. Зураг төсөл боловсруулах чиглэлээр		
1.	Бага төвөгшилтэй	50,000
2.	Дунд, Өндөр төвөгшилтэй	150,000
3.	Онцгой төвөгшилтэй	200,000
4.	Тухайлсан	250,000
Хоёр. Барилгын ажил гүйцэтгэх чиглэлээр		
1.	Бага төвөгшилтэй	100,000
2.	Дунд, Өндөр төвөгшилтэй	200,000
3.	Онцгой төвөгшилтэй	300,000
4.	Тухайлсан	350,000
Гурав. Өргөх байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл, угсралт, засвар үйлчилгээний чиглэлээр		
1.	Дунд төвөгшилтэй	50,000
2.	Өндөр төвөгшилтэй	100,000
3.	Онцгой төвөгшилтэй	200,000
Дөрөв. Барилгын материалын үйлдвэрлэлийн чиглэлээр		
1.	Бага хүчин чадалтай	50,000
2.	Дунд хүчин чадалтай	100,000
3.	Өндөр хүчин чадалтай	150,000

Тайлбар:

1. Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах "өндөр" төвөгшилд 3Т-6, 3Т-10, 3Т-11, 3Т-12-ын заалтууд хамаарна.

Handwritten signature or mark.

2. Барилга байгууламжийн ажил гүйцэтгэх "эндөр" төвөгшилд БА-6-ын заалт хамаарна.

3. Барилгын материалын үйлдвэрлэлийн МУ-3.3, 3.4, 3.5 болон 7, 9, 10-ын заалтуудад хамаарах тусгай зөвшөөрөл нь "дунд" хүчин чадалтайд хамаарна.

4. Барилгын материалын үйлдвэрлэлийн 11 дэх заалтад хамаарах эрчим хүчний хэмнэлттэй барилгын материалын үйлдвэрийн тусгай зөвшөөрлийн үйлчилгээний суурь хураамж 200,000 төгрөг байна.

---oOo---

2021

11